



УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9 дэх заалт, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/172 дугаар захирамж нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын архивын баримтын хадгалалтын нөхцөлийг сайжруулж, зориулалтын хадгаламжийн сангийн өрөөтэй болсонтой холбогдуулан албан хэрэгцээнд зориулж архивын бичиг баримт хадгалах 3 ширхэг тавиур авсугай.

2. Архивын баримтын хадгалалтын тавиур авахад шаардагдах 460.000 /дөрвөн зуун жаран мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Оюунжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Ч.ГАН-ОЧИР